

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
Одоогийн мөрдөгдөж буй хууль болон УИХ-аас 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр баталсан
хуулийг харьцуулах нь

	Одоогийн мөрдөгдөж буй хууль	Шинэ хууль
Албан татвар төлөгч	<ul style="list-style-type: none"> • Монгол Улсын нутаг дэвсгэрт бараа импортлож байгаа болон экспортолж байгаа түүнчлэн аливаа бараа үйлдвэрлэж борлуулж, ажил гүйцэтгэж, үйлчилгээ үзүүлж байгаа этгээд 	<ul style="list-style-type: none"> • Монгол Улсын нутаг дэвсгэрт бараа импортолсон болон экспортолсон, түүнчлэн бараа үйлдвэрлэсэн буюу борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн этгээд • борлуулалтын орлогын хэмжээ нь 10 сая ба түүнээс дээш төгрөгт хүрсэн гадаадын хуулийн этгээдийн төлөөний газар
НӨАТ-ын босго/НӨАТ төлөгчийг бүртгэх	<ul style="list-style-type: none"> • 10 сая төгрөгөөс дээш жилийн борлуулалтын орлого • 10 сая төгрөгийн 80 хувь хүрсэн бол сайн дураараа • НӨАТ төлөгчөөр бүртгүүлсэн этгээдийн орлого 10 сая төгрөг хүрэхгүй нөхцөлд харьяалах татварын алба нь түүнийг татвар төлөгчийн бүртгэлээс хасна 	<ul style="list-style-type: none"> • 10 сая төгрөгөөс дээш жилийн борлуулалтын орлого • 10 сая төгрөгийн 80 хувь хүрсэн бол сайн дураараа • Монгол Улсад 2.0 сая ам. доллар ба түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн бол сайн дураараа • Орлого болон хөрөнгө оруулалт нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, олон улсын стандартын дагуу хөтөлж хэвшсэн байх ёстой • НӨАТ төлөгчөөр бүртгүүлсэн этгээдийн орлого 10 сая төгрөг хүрэхгүй нөхцөлд харьяалах татварын алба нь түүнийг татвар төлөгчийн бүртгэлээс хасна
Татвар ногдуулах бараа, ажил, үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> • Монгол Улсын нутаг дэвсгэрт борлуулсан бараа • Монгол Улсын нутаг дэвсгэрээс экспортлосон бараа • Монгол Улсын нутаг дэвсгэрт гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээ • Монгол Улсын нутаг дэвсгэрт импортлосон бүх төрлийн бараа • "Бараа борлуулсан" гэдэгт хамааруулах: <ul style="list-style-type: none"> ○ Эрхэлж буй аж ахуйн болон тодорхой бизнес эрхлэх эрхийг борлуулах ○ Үйлдвэрлэл, үйлчилгээгээ зогсоох үед бизнесийн хөрөнгөөс өөрт үлдээсэн бараа, ажил, үйлчилгээ ○ НӨАТ-ыг нь буцааж олгох аливаа бараа, ажил, үйлчилгээ ○ Бусад этгээдэд өрийн төлбөр болгон өгсөн бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээ • "Үйлчилгээ үзүүлсэн" гэдэгт хамааруулах: 	<ul style="list-style-type: none"> • Монгол Улсын нутаг дэвсгэрт борлуулсан бүх төрлийн бараа • Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадаад улсад экспортолсон бүх төрлийн бараа • Монгол Улсын нутаг дэвсгэрт гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээ • гадаад улсаас Монгол Улсын нутаг дэвсгэрт импортолсон бүх төрлийн бараа • "Бараа борлуулсан" -д хамааруулах: <ul style="list-style-type: none"> ○ Аж ахуйн болон тодорхой бизнес эрхлэх эрхийг борлуулах ○ Худалдаа, үйлдвэрлэл, ажил, үйлчилгээгээ зогсоох үед бизнесийн хөрөнгөөс өөртөө үлдээх бараа, ажил, үйлчилгээ ○ НӨАТ-ын хасалт хийх аливаа бараа, ажил, үйлчилгээ ○ Өрийн төлбөрийг аливаа бараа, ажил

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
Одоогийн мөрдөгдөж буй хууль болон УИХ-аас 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр баталсан
хуулийг харьцуулах нь

	Одоогийн мөрдөгдөж буй хууль	Шинэ хууль
	<ul style="list-style-type: none"> ○ цахилгаан, дулаан, хий, ус гэх мэт үйлчилгээ ○ Бараа түрээслүүлэх ○ Байр түрээслүүлэх ○ Эрх худалдах, шилжүүлэх ○ Хонжворт тоглоом тоглуулах 	<p>үйлчилгээ борлуулах замаар хаах</p> <ul style="list-style-type: none"> ○ Оршин суугч бус хувь хүн Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн захиалгаар бараа борлуулах • "Үйлчилгээ үзүүлсэн"-д хамааруулах: <ul style="list-style-type: none"> ○ цахилгаан, дулаан, хий, ус гэх мэт үйлчилгээ ○ бараа түрээслүүлэх, эзэмшүүлэх ○ байр түрээслүүлэх ○ эрх худалдах буюу шилжүүлэх ○ бооцоот тоглоом тоглуулах ○ байшин, барилгаас бусад үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө түрээслүүлэх ○ оюуны өмчийг шилжүүлэх, түрээслүүлэх, худалдах ○ өрийн төлбөрийг ажил, үйлчилгээ үзүүлэх замаар хаах ○ оршин суугч бус хувь хүнээс Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн захиалгаар ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх ○ буруутай үйл ажиллагааны улмаас бусдад хүү, торгууль төлөх ○ НӨАТ-ын хасалт хийх аливаа ажил, үйлчилгээ
Албан татварын хувь, хэмжээ	<ul style="list-style-type: none"> • Импортлосон болон борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний татвар тооцох үнэлгээний 15% • Экспортод гаргасан бараа, ажил, үйлчилгээнд ногдуулах НӨАТ-ын хувь тэг ("0")-тэй тэнцүү байна 	<ul style="list-style-type: none"> • Импортлосон болон үйлдвэрлэсэн, борлуулсан бараа, ажил, үйлчилгээний албан татвар тооцох үнэлгээний 10% • Экспортод гаргасан бараа, ажил, үйлчилгээнд ногдуулах НӨАТ-ын хувь тэг ("0")-тэй тэнцүү байна
НӨАТ ногдуулах журам		<ul style="list-style-type: none"> • Албан татвар ногдуулах журам: <ul style="list-style-type: none"> ○ Импортлосон буюу экспортолсон, түүнчлэн борлуулсан бол тухай бүрт ○ Барилга угсралтын ажил гүйцэтгэсэн бол эцсийн борлуулалтад ○ Санхүүгийн түрээс төлбөр хийхээр тохирсон хуваарийг баримтлан тухай бүрт

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
Одоогийн мөрдөгдөж буй хууль болон УИХ-аас 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр баталсан
хуулийг харьцуулах нь

	Одоогийн мөрдөгдөж буй хууль	Шинэ хууль
		<ul style="list-style-type: none"> • Сангийн яамнаас баталсан Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллыг баримтлах шаардлагатай
НӨАТ тооцох үнэлгээ	<ul style="list-style-type: none"> • Импортлолсон бараа: гаалийн үнэ дээр гаалийн албан татвар болон бусад албан татварыг нэмж • Борлуулсан бараа, ажил, үйлчилгээ: борлуулсан үнэ буюу тухайн үеийн зах зээлийн үнэ, тарифыг үндэслэн • Харилцан солилцсон бараа, ажил, үйлчилгээ: тухайн үеийн зах зээлийн үнэ, тарифыг үндэслэн • Хонжворт тоглоомын үйлчилгээ: олсон орлогоос хожлын төлбөрт төлсөн мөнгөний хэмжээг хасч 	<ul style="list-style-type: none"> • Импортын бараа: гаалийн үнэ дээр гаалийн албан татвар болон бусад албан татварыг нэмж • Борлуулсан бараа, ажил, үйлчилгээ: борлуулсан үнэ буюу тухайн үеийн зах зээлийн үнэ, тарифыг үндэслэн • Харилцан солилцсон бараа, ажил, үйлчилгээ: тухайн үеийн зах зээлийн үнэ, тарифыг үндэслэн • Бооцоот тоглоомын үйлчилгээ: олсон орлогоос хожлын төлбөрт төлсөн мөнгөний хэмжээг хасч
Харилцан хамаарал бүхий этгээдүүд	<ul style="list-style-type: none"> • Хэт хямд эсхүл хэт өндөр үнэ тарифаар бараа, ажил, үйлчилгээ борлуулсан бол тухайн үеийн зах зээлийн үнэ, тарифыг үндэслэх 	<ul style="list-style-type: none"> • Хоёр буюу түүнээс дээш хуулийн этгээдийн эд хөрөнгө буюу саналын эрхийн 66-аас дээш хувийг нэг буюу хэд хэдэн хуулийн этгээд эзэмшиж байвал тэдгээрийг нэг бүлэг болгон бүртгэж болно; нэг бүлэгт хамрагдсан гишүүн тус бүр нь НӨАТ төлөгч байна • Аль нэг гишүүн тухайн бүлгийн нэрийн өмнөөс НӨАТ-тай холбогдох үүрэг хүлээнэ. • Хэт хямд эсхүл хэт өндөр үнэ тарифаар бараа, ажил, үйлчилгээ борлуулсан бол тухайн үеийн зах зээлийн үнэ, тарифыг үндэслэх
НӨАТ-ын тэг (“0”) хувь, хэмжээг хэрэглэх	<ul style="list-style-type: none"> • Худалдах зориулалтаар экспортод гаргасан бараа • Гадаад улсад эсхүл гадаад улсаас гаргасан зорчигч болон ачаа тээврийн үйлчилгээ • Хөдлөх буюу үл хөдлөх хөрөнгөтэй шууд холбоотойгоор үзүүлсэн үйлчилгээнд хамаарахгүй Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадна үзүүлсэн үйлчилгээ • Олон улсын агаарын тээврийн хөлөгт үзүүлсэн үйлчилгээ 	<ul style="list-style-type: none"> • Худалдах зориулалтаар экспортод гаргасан бараа • гадаад улсад, гадаад улсаас үзүүлсэн зорчигч болон ачаа тээврийн үйлчилгээ • гадаад улсад үзүүлсэн үйлчилгээ (үүнд Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа хөдлөх, үл хөдлөх хөрөнгөтэй шууд холбоотойгоор үзүүлсэн үйлчилгээ хамаарахгүй) • үйлчилгээ үзүүлэх үед Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаагүй гадаад улсын иргэн, хуулийн этгээдэд үзүүлсэн үйлчилгээ • гадаадын агаарын тээврийн хөлөгт үзүүлэх үйлчилгээ • дотоодод үйлдвэрлэсэн төрийн одон, медаль, зоос

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
Одоогийн мөрдөгдөж буй хууль болон УИХ-аас 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр баталсан
хуулийг харьцуулах нь

	Одоогийн мөрдөгдөж буй хууль	Шинэ хууль
НӨАТ-аас чөлөөлөх үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> • Санхүүгийн үйлчилгээ: <ul style="list-style-type: none"> ○ Валют солих ○ Банкны үйлчилгээ ○ Даатгал, эд хөрөнгийн бүртгэлийн үйлчилгээ ○ Үнэт цаас гаргах, шилжүүлэх, хүлээн авах, баталгаа гаргах үйлчилгээ ○ Урьдчилгаа, зээл ○ Нийгмийн даатгалын сангийн хүүг олгох, шилжүүлэх ○ Банкны хүү, ногдол ашиг, зээлийн баталгаа, даатгалын гэрээний хураамж ○ Санхүүгийн түрээс • Орон сууцанд амьдран суух зориулалтаар байр түрээслүүлэх үйлчилгээ • Боловсролын үйлчилгээ • Эрүүл мэндийн үйлчилгээ • Шашны байгууллага • Төрийн байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээ • Оршуулгын үйлчилгээ • Нийтийн тээврийн үйлчилгээ • Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч байгууллагын гадаадын жуулчдад үзүүлсэн үйлчилгээ 	<ul style="list-style-type: none"> • Санхүүгийн үйлчилгээ: <ul style="list-style-type: none"> ○ Валют солих ○ Банкны үйлчилгээ ○ Даатгал, эд хөрөнгийн бүртгэлийн үйлчилгээ ○ Үнэт цаас гаргах, шилжүүлэх, хүлээн авах, баталгаа гаргах үйлчилгээ ○ Урьдчилгаа, зээл ○ Нийгмийн даатгалын сангийн хүүг олгох, шилжүүлэх ○ Банкны хүү, ногдол ашиг, зээлийн баталгаа, даатгалын гэрээний хураамж ○ Санхүүгийн түрээс • Орон сууцанд амьдран суух зориулалтаар байр түрээслүүлэх үйлчилгээ • Боловсролын үйлчилгээ • Эрүүл мэндийн үйлчилгээ • Шашны байгууллага • Төрийн байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээ • Нийтийн тээврийн үйлчилгээ • Аялал жуулчлалын компаниас гадаадын жуулчдад үзүүлэх жуулчдад үйлчлэх бааз, ресторан, жуулчин тээвэрлэх болон зочид буудлаас бусад үйлчилгээ
НӨАТ-аас чөлөөлөх бараа	<ul style="list-style-type: none"> • Зорчигчийн биедээ авч яваа хувийн хэрэглээний бараа • Гадаадын дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагын хэрэгцээнд зориулан импортлосон бараа; • Тухайн улсаас Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газрын албан ажлын хэрэгцээнд зориулж Монгол Улсын нутаг дэвсгэрт худалдан авсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээ (буцаан олгох нөхцөлөөр) • Гадаад улсын Засгийн газар, төрийн бус 	<ul style="list-style-type: none"> • Зорчигчийн биедээ авч яваа хувийн хэрэглээний бараа • Гадаадын дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагын хэрэгцээнд зориулан импортлосон бараа; • Тухайн улсаас Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газрын албан ажлын хэрэгцээнд зориулж Монгол Улсын нутаг дэвсгэрт худалдан авсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээ (буцаан олгох нөхцөлөөр) • Гадаад улсын Засгийн газар, төрийн бус байгууллага,

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
Одоогийн мөрдөгдөж буй хууль болон УИХ-аас 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр баталсан
хуулийг харьцуулах нь

	Одоогийн мөрдөгдөж буй хууль	Шинэ хууль
	<p>байгууллага, олон улсын болон буяны байгууллагаас буцалтгүй болон хүмүүнлэгийн тусламжаар авсан бараа</p> <ul style="list-style-type: none"> • Тахир дутуу хүмүүст зориулсан тусгай зориулалтын хэрэгсэл • Батлан хамгаалах, хууль сахиулах хэрэгцээнд зориулан авч буй зэвсэг гэх мэх • Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн хөдөө аж ахуй, ой, ан агнуурын анхдагч түүхий эд • Тэргүүлэх ач холбогдол бүхий салбарт болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хөрөнгө оруулж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж үйлдвэрлэл явуулахдаа технологийн зориулалтаар ашиглах, угсарч суурилуулах тоног төхөөрөмж, хүнд механизм • Шинээр барьж байгуулсан орон сууцны зориулалттай байрнаас бусад орон сууцны зориулалтаар ашиглаж байгаа байрыг борлуулах • Газрын тосны салбарт Засгийн газартай байгуулсан гэрээний дагуу импортолсон техник, тоног төхөөрөмж гэх мэт • Эх орондоо бүрмөсөн буцаж ирж байгаа Монгол Улсын дипломатын хувийн хэрэглээний нэг суудлын автомашин • Эмчилгээний зориулалтаар хэрэглэх цус, цусан бүтээгдэхүүн, эд, эрхтэн • Борлуулсан алт • Засгийн газраас баталсан хийн түлш, хийн түлшний сав, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын машин, техник, хэрэгсэл, тоноглол 	<p>олон улсын болон буяны байгууллагаас буцалтгүй болон хүмүүнлэгийн тусламжаар авсан бараа</p> <ul style="list-style-type: none"> • Тахир дутуу хүмүүст зориулсан тусгай зориулалтын хэрэгсэл • Батлан хамгаалах, хууль сахиулах хэрэгцээнд зориулан авч буй зэвсэг гэх мэх • Иргэний агаарын зорчигч тээврийн хөлөг, түүний сэлбэг • Шинээр барьж байгуулсан орон сууцны зориулалттай байрнаас бусад орон сууцны зориулалтаар ашиглаж байгаа байрыг борлуулах • Газрын тосны салбарт Засгийн газартай байгуулсан гэрээний дагуу импортолсон техник, тоног төхөөрөмж гэх мэт • Эмчилгээний зориулалтаар хэрэглэх цус, цусан бүтээгдэхүүн, эд, эрхтэн • Засгийн газраас баталсан хийн түлш, хийн түлшний сав, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын машин, техник, хэрэгсэл, тоноглол • Гадаад улсад захиалгаар хийлгэсэн Монгол Улсын мөнгөн тэмдэгт • Борлуулсан алт • Сонин
НӨАТ-аас чөлөөлөх үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид	<ul style="list-style-type: none"> • Жилийн 10 сая ба түүнээс доош төгрөгийн татвар ногдох борлуулалтын орлоготой импортлогчдоос бусад үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид 	<ul style="list-style-type: none"> • Жилийн 10 сая ба түүнээс доош төгрөгийн татвар ногдох борлуулалтын орлоготой импортлогчдоос бусад үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
Одоогийн мөрдөгдөж буй хууль болон УИХ-аас 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр баталсан
хуулийг харьцуулах нь

	Одоогийн мөрдөгдөж буй хууль	Шинэ хууль
НӨАТ ногдуулах хугацаа	<ul style="list-style-type: none"> • Аль түрүүнд хийгдсэн өдрөөр тогтооно: <ul style="list-style-type: none"> ○ Борлуулагчийн падаан үйлдсэн өдөр ○ Борлуулагч худалдсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний үнэ, хөлсийг авсан өдөр ○ Бараа болон ажил, үйлчилгээг худалдан авсан өдөр • Импортын барааг гаалийн байгууллагад мэдүүлсэн өдөр 	<ul style="list-style-type: none"> • Аль түрүүнд хийгдсэн өдрөөр тогтооно: <ul style="list-style-type: none"> ○ Борлуулагчийн падаан үйлдсэн өдөр ○ Борлуулагч худалдсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний төлбөрийг хүлээн авсан өдөр ○ Бараа болон ажил, үйлчилгээг худалдан авсан өдөр • Жижиглэнгийн худалдаа эрхлэгч борлуулалт хийх бүрдээ падаан бичнэ • Импортын барааг гаалийн байгууллагад мэдүүлсэн өдөр
НӨАТ-ын хасалт хийх	<ul style="list-style-type: none"> • Хасалт хийх татвар: <ul style="list-style-type: none"> ○ Үйлдвэрлэл, үйлчилгээнийхээ үйл ажиллагаанд зориулан худалдан авсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд төлсөн татвар ○ худалдах зориулалтаар болон үйлдвэрлэл, үйлчилгээнийхээ үйл ажиллагаанд зориулан өөрөө шууд импортлосон бараа, ажил, үйлчилгээнд төлсөн татвар • НӨАТ нь нэхэмжлэлээр баталгаажсан байх ёстой • Дараахь бараа, ажил, үйлчилгээнээс хасалт хийхгүй: <ul style="list-style-type: none"> ○ Суудлын автомашин, түүний эд анги, сэлбэг ○ Хувьдаа болон ажиллагсдын хэрэгцээнд зориулан худалдаж авсан бараа, үйлчилгээ ○ Албан татвараас чөлөөлсөн импортлосон болон худалдаж авсан бараа, ажил, үйлчилгээ • Хасалт хийх албан татварын хэмжээ нь төлбөл зохих уг татварын дүнгээс их байвал дараахь байдлаар зохицуулах: <ul style="list-style-type: none"> ○ Дараа төлөх албан татварт тооцох ○ Бусад төрлийн албан татварын өрөнд тооцох ○ Үйлдвэрлэгч-экспортлогчоос бусад татвар төлөгчийн татварыг төсвөөс буцаан олгох ○ Гадаадын дипломат төлөөлөгчийн газрын хувьд албан татварыг буцаан олгуулах асуудлыг Сангийн яаманд уламжлан шийдвэрлүүлэх 	<ul style="list-style-type: none"> • Хасалт хийх татвар: <ul style="list-style-type: none"> ○ үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар худалдан авсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд төлсөн ○ худалдах, түүнчлэн үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар өөрөө шууд импортлосон бараа, ажил, үйлчилгээнд төлсөн ○ Үйлдвэрлэл эрхлэгчид зарим мал аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүн боловсруулах зорилгоор худалдан авсан бол барааны үнэд нь 10 хувийн НӨАТ шингэсэн гэж үзнэ • НӨАТ нь нэхэмжлэлээр баталгаажсан байх ёстой • Дараахь бараа, ажил, үйлчилгээнээс хасалт хийхгүй: <ul style="list-style-type: none"> ○ Гэрээ, дүрмийн дагуу худалдан авч буй хуулийн этгээдээс бусад этгээдээс худалдан авсан суудлын авто машин, түүний эд анги, сэлбэг ○ Хувьдаа болон ажиллагсдын хэрэгцээнд зориулан худалдаж авсан бараа, үйлчилгээ ○ Албан татвараас чөлөөлсөн импортлосон болон худалдаж авсан бараа, ажил, үйлчилгээ • Хасалт хийх албан татварын хэмжээ нь төлбөл зохих уг татварын дүнгээс их байвал дараахь байдлаар зохицуулах: <ul style="list-style-type: none"> ○ дараа нь төлөх албан татварт тооцох ○ бусад төрлийн албан татварын төлбөрт

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
Одоогийн мөрдөгдөж буй хууль болон УИХ-аас 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр баталсан
хуулийг харьцуулах нь

	Одоогийн мөрдөгдөж буй хууль	Шинэ хууль
		<p align="center">шилжүүлэн тооцох</p> <ul style="list-style-type: none"> Албан татвар төлөгч нь түүнийг буцаан авах хүсэлтээ гаргасан бол төлбөл зохих албан татварын дүнгээс илүү гарсан хэсгийг буцаан олгоно
Импортын бараа	<ul style="list-style-type: none"> Импортын бараанд НӨАТ ногдуулах, төлүүлэх үйл ажиллагааг гаалийн байгууллага хариуцна Ногдуулсан НӨАТ-ын ажлын 3 хоногийн дотор төлнө Гаалийн байгууллага НӨАТ-ыг дансанд орсноос хойш ажлын 3 өдөрт багтаан төсөвт шилжүүлнэ Татварын сарын тайланг дараа сарын 10-ны дотор, жилийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор гаргаж Сангийн яаманд ирүүлнэ 	<ul style="list-style-type: none"> Импортын бараанд НӨАТ ногдуулах, төлүүлэх үйл ажиллагааг гаалийн байгууллага хариуцна Татварын сарын тайланг дараа сарын 10-ны дотор, жилийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор гаргаж Сангийн яаманд ирүүлнэ
Татварын тайлан	<ul style="list-style-type: none"> Дараа сарын 10-ны дотор НӨАТ-ыг төлж сарын тайланг гаргана 	<ul style="list-style-type: none"> Дараа сарын 10-ны дотор НӨАТ-ыг төлж сарын тайланг гаргана
Хууль, тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага	<ul style="list-style-type: none"> Татвар төлөгчөөр бүртгүүлбэл зохих иргэн, хуулийн этгээд бүртгүүлээгүй бол НӨАТ ногдох орлогын дүнгийн 8 хувьтай тэнцэх торгууль ногдуулна Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлж, гэрчилгээ аваагүй боловч татвар ногдуулж байсан бол түүнийг төсөвт нөхөн төлүүлж нэхэмжилж авсан өдрөөс хойшхи хоног тутамд нөхөн төлүүлсэн татварын дүнгээс бодож 1 хувийн хүү ногдуулна 	<ul style="list-style-type: none"> Татвар төлөгчөөр бүртгүүлбэл зохих иргэн, хуулийн этгээд бүртгүүлээгүй буюу бүртгүүлээд үйл ажиллагаа явуулан орлого олж НӨАТ төлөөгүй бол дараахь хариуцлага хүлээлгэнэ: <ul style="list-style-type: none"> Нөхөн төлбөл зохих бүх татвар Нөхөн төлбөл зохих НӨАТ-ын нийт дүнгээс 0.3 хувиар тооцож хүү төлүүлэх нөхөн төлбөл зохих НӨАТ-ын дүнгийн 50 хувиас илүүгүй хэмжээгээр торгууль ногдуулах Албан татвар төлөгчөөр бүртгүүлэх нөхцөлийг хангасан ч бүртгүүлээгүй бөгөөд НӨАТ ногдуулж байсан бол <ul style="list-style-type: none"> Нөхөн төлбөл зохих бүх татвар Нөхөн төлбөл зохих НӨАТ-ын нийт дүнгээс 0.3 хувиар тооцож хүү төлүүлэх Нөхөн төлбөл зохих татварын дүнгээс илүүгүй хэмжээний торгууль
Хүчингүй болсон хуулиуд		<ul style="list-style-type: none"> Иргэний үнэмлэх хэвлэх материал, тоног төхөөрөмж, сэлбэгийг НӨАТ-аас чөлөөлөх тухай "Мянганы зам" төслийг НӨАТ-аас чөлөөлөх тухай "Булган, Мөрөнгийн хооронд шилэн кабелийн

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
Одоогийн мөрдөгдөж буй хууль болон УИХ-аас 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр баталсан
хуулийг харьцуулах нь

	Одоогийн мөрдөгдөж буй хууль	Шинэ хууль
		<p>дамжуулах сүлжээ тавих” төслийн хүрээнд материал, тоног төхөөрөмжийн импортыг НӨАТ-аас чөлөөлөх тухай</p> <ul style="list-style-type: none"> • Баруун бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ ХХК-ний импортлосон цахилгааныг НӨАТ-аас чөлөөлөх тухай • Зарим материал, машин механизм, тоног төхөөрөмж, бараа, ажил, үйлчилгээг НӨАТ-аас чөлөөлөх тухай • 1998 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн НӨАТ-ын хууль